



ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ  
ТӨРИЙН ӨМЧИЙН ХУВЬЦААТ КОМПАНИ

**220 КВ-ЫН БЭЛТГЭЛ ТРАНСФОРМАТОР-2-ЫН ЯЧЕЙКИЙН ТОНОГЛОЛЫН  
СУУРИЙН БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН  
ШАЛГАРУУЛАХ ХАРЬЦУУЛАЛТЫН  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Харьцуулалтын тендерийн дугаар: ЦДҮС-2019/ИХБ-4/ХА03

Улаанбаатар хот  
2019

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос 220 кВ-ын бэлтгэл трансформатор-2-ын ячейкийн тоноглолын суурийн барилга угсралтын ажил гүйцэтгэх тухай үнийн санал Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, ажлын зураг болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерийг 2019 оны 08 дугаар сарын 02-ны 10:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг Улаанбаатар хот-36 Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-45 “ЦДҮС” ТӨХК-ний байр 3 дугаар давхар 309 тоотод 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 10:10 цагт тендерийг нээнэ.

***Улаанбаатар-17060, Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-22/1, “ЦДҮС”  
ТӨХК-ний Төв байр, 3 дугаар давхар, 309 тоот  
Худалдан авах ажиллагаа, ханган нийлүүлэлтийн хэлтэс***

***Утас: 99039494, Факс: 976-7004328***

***Email: [saintugs@transco.mn](mailto:saintugs@transco.mn)***

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
    - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйлд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
    - 1.2. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:
      - **БА 2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл шинэчлэлийн ажил**
    - 1.3. Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: Тусгай зөвшөөрлийн шаардлагын дагуу ажил гүйцэтгэхэд шаардлагатай багаж, техник хэрэгсэл, машин механизм.
  2. Тендерийн иж бүрдэл
    - 2.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
      - (а) Үнийн санал;
      - (б) Үнэлэгдсэн ажлын тоо хэмжээ;
      - (в) Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг; Үүнд:
        - Сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/;
        - Сүүлийн нэг жилийн борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
        - Татварын цахим тодорхойлолт;
        - Татвар хураамжаа бүрэн төлсөн, өр төлбөргүй байна.
        - Сүүлийн нэг жилд төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;
        - Сүүлийн нэг жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээтэй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна.
        - Барилгын инженер болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженерийн анкет, чадвар, туршлагын талаарх мэдээлэл; **Тусгай зөвшөөрлийн шаардлагын дагуу байна.**
        - Улсын бүртгэлийн гэрчилгээ; /нотариатаар баталгаажуулсан/
        - Компанийн танилцуулга;
        - Шаардлагатай багаж, техник хэрэгсэл, машин механизмын жагсаалт;
      - (г) Ажлын тоо хэмжээ, ажлын зургийн дагуу Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм дүрмийн дагуу төсөв зохиох программаар төсөв хийж мэргэжсэн төсөвчнөөр баталгаажуулж ирүүлнэ.
- Дээрх баримт материалыг ирүүлээгүй, ирүүлсэн материал дутуу бөгөөд үнэн зөв эсэх нь нотлогдоогүй тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.**
3. Тендерийн үнэ
    - 3.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн ажлын тоо хэмжээнд үндэслэнэ.
    - 3.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

- 3.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ ажлын тоо хэмжээнд тодорхойлогдсон бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
- 3.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг нэгж болон нийт үнэ, тендерийн нийт үнэд багтаасан байна.
4. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа
- 4.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Алдааг залруулах
- 5.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 5.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
6. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 6.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 6.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
7. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 7.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

- |  |   |
|--|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| 2. Төслийн менежерийн шийдвэр                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| 4. Аюулгүй байдал                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй.   |
| 6. Маргааныг шийдвэрлэх                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

### Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- |                              |   |
|------------------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр            | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг  |

ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.

- |                                      |   |
|--------------------------------------|---|
| 9. Зөрчил, гологдол арилгах          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |
|                                      | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.  |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.                           |

## В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- |                               |   |
|-------------------------------|---|
| 11. Ажлын тоо хэмжээ          | 11.1. Ажлын тоо хэмжээнд барилга угсралт, суурилуулалт, туршилт болон ашиглалтад оруулах зэрэг гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх ажлын нэр терлийг тусгана   |
|                               | 11.2. Ажлын тоо хэмжээг гэрээний үнийг тооцоход ашиглана. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын хөлсийг ажлын тоо хэмжээнд заасан тухайн нэр терлийн ажлын нэгж үнээр тооцож телне.   |
| 12. Ажлын тоо хэмжээг өөрчлөх | 12.1. Хэрэв гүйцэтгэсэн ажлын эцсийн тоо хэмжээ нь ажлын тоо хэмжээнд тусгагдсан тухайн нэр терлийн ажлын тоо хэмжээнээс 25-аас илүү хувиар зерж, үүнээс шалтгаалсан еерчлелт нь гэрээний анхны үнээс 1-ээс илүү хувиар хэтэрвэл төслийн менежер энэхүү еерчлелтийн дагуу нэгж үнийг тохируулна.  |
|                               | 12.2. Хэрэв ажлын тоо хэмжээ еерчлөгдсөний улмаас гэрээний анхны үнэ 15-аас илүү хувиар есехеер бол захиалагч урьдчилан баталснаас бусад тохиолдолд төслийн менежер еерчлелтийн дагуу нэгж үнийг тохируулах эрхгүй.   |
|                               | 12.3. Гүйцэтгэгч нь ажлын тоо хэмжээнд тусгагдсан аливаа зардлын нэгж үнийн дэлгэрэнгүй задаргааг төслийн менежер шаардсаны дагуу гаргаж өгнө.  |
| 13. Алданги                   | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |

## Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- |                  |  |
|------------------|--|
| 14. Ажил дуусгах | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна. |
|------------------|--|

15. Хүлээж авах 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
18. Гэрээг цуцлах 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 48 хоногийн дотор төлөөгүй;
  - (д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (е) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан

алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
20. Гүйцэтгэлээс чөлөөлөх
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.



## Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: **220 кВ-ын бэлтгэл трансформатор-2-ийн ячейкийн тоноглолын суурийн барилга угсралтын ажил, ЦДҮС-2019/ИХБ-4/ХА03**
- 1.1 Ажил нь 220 кВ-ын бэлтгэл трансформатор-2-ийн ячейкийн тоноглолын суурийн барилга угсралтын ажил зэрэг техникийн тодорхойлолт, ажлын зураг төсөлд заасан ажлаас бүрдэнэ.
- Ажлын талбайн байршил: ДЦС-4 ТӨХК-ийн дэргэдэх 220/110 кВ-ын ИХБ-4.
- 2.1 Төслийн менежер нь ЦДҮС ТӨХК-ийн УБС-ын Ерөнхий инженер байна.
- 3.1 Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулсан өдрөөс хойш 3 хоногийн дотор эхлүүлнэ.
- Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Гэрээ байгуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор дуусгаж хүлээлгэн өгнө.
- 7.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргаж ирүүлнэ.
- 9.1 Чанарын баталгаат хугацаа **3 /гурав/** жил байна.
- 13.1 Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн **0.05%** байна.
- Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн **5%** байна.
- 17.1 Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг ашиглалтанд оруулснаас хойш 7 хоногийн дотор гаргаж өгнө.
- Гүйцэтгэлийн зургийг ашиглалтанд оруулснаас хойш 7 хоногийн дотор гаргаж өгнө.
- Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 1.0 сая төгрөг байна.
- 19.1 Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын *[0 хувь]*-иар тооцно.

## **Тав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ/ХИЙГДЭХ АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ**

Эрчим хүчний зураг төслийн Шугам ХХК-ийн боловсруулж ЭХХТ ТӨҮГ-ийн магадлал хийсэн доорх ажлын зургийг хавсаргав. Үүнд:

- **220/110 кВ-ын “ИЛ ХУВААРИЛАХ БАЙГУУЛАМЖ-4”-ИЙН АТ-1, АТ-2 АВТОТРАНСФОРМАТОРЫН ХОЛБОЛТЫН ӨӨРЧЛӨЛТ (ИХБ-4-ИЙН ӨТГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛТ) (Ажлын зураг)  
ДЭВТЭР I. АНХДАГЧ ХЭЛХЭЭ  
Тайлбар бичиг, зургууд, материалыг түүвэр  
ЕГ Шифр: SH19-08-I**

Энэхүү ажлын зурагт **220 кВ-ын бэлтгэл трансформатор-2ийн ячейкийн тоноглолын суурийн ажил** бүрэн хэмжээгээр орсон болно.

Одоо байгаа тоног төхөөрөмжийг буулгах, шинээр угсарч суурилуулах, кабель болон шин угсрах ажлыг Улаанбаатар салбар өөрсдийн хүчээр хийж гүйцэтгэнэ.

### **220 кВ-ЫН БЭЛТГЭЛ ТРАНСФОРМАТОР-2-ИЙН ЯЧЕЙКИЙН ТОНОГЛОЛЫН СУУРИЙН АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ**

<b>№</b>	<b>Гүйцэтгэх ажлын нэр</b>	<b>Хэмжих нэгж</b>	<b>Тоо хэмжээ</b>
<b><u>220 кВ-ын ИХБ-ын өргөтгөлийн газар шорооны ажил</u></b>			
1	Тоноглолуудын суурийн нүхийг 3-р зэргийн хөрсийг механизмаар ухаж овоолох	МЗ	<b>570.94</b>
2	Тоноглолуудын суурийн нүхийг механизмаар ухсаныг засаж гараар ухах	МЗ	<b>18.59</b>
3	Тоноглолуудын суурийн нүхийг механизмаар булах	МЗ	<b>297.3145</b>
4	1, 2-р зэргийн хөрсийг өндөр бүтээмжтэй хийн тромбовкоор нягтруулах	МЗ	<b>109.95</b>
<b><u>220 кВ-ын ИХБ-ын өргөтгөлийн суурийн ажил</u></b>			
1	220кВ-ын тоноглолуудын суурийн бетон бэлтгэл хийх В7.5	МЗ	<b>15.184</b>
2	220кВ-ын тоноглолуудын төмөр бетон суурь цутгах В25	МЗ	<b>25.35</b>
3	220кВ-ын тоноглолуудын төмөр бетон суурь арматурчлах	Тонн	<b>6.104</b>
5	Бетонон суурийн тэгшилсэн гадаргууд ус тусгаарлагчийг битум түрхлэгээр 2 үе хийх	М2	<b>419.79</b>

#### **Тайлбар:**

**220 кВ-ын бэлтгэл трансформатор-2-ийн ячейкийн сунгах 2 порталын суурь (нийт 8ш), анкер тулгуурын суурийн (нийт 4 ш) ажил нь энэ ажилд ороогүй болно.**

## **Барилга угсралтын ажлын үед тавигдах шаардлага**

- Барилга угсралтын ажлыг захиалагч, шалгарсан гүйцэтгэгчийн хамт ашиглагч байгууллагын удирдлагуудтай уулзаж, ажил эхлүүлэх тухай тэмдэглэл хөтлөж, ажил эхлүүлнэ.
- Тухайн барилгын ашиглагчтай ярилцаж, зөвшилцсөний дагуу ажилчдын түр байрлах өрөө, шаардлагатай нөхцөлд барилгын материал агуулах өрөө тасалгаа гаргуулж авсан байна.
- БУА-ыг тендерийн бичиг баримтад өгөгдсөн ажлын зураг, ажлын тоо хэмжээний дагуу гүйцэтгүүлнэ.
- Ажлын явцад зайлшгүй шаардлагатай өөрчлөлт оруулах нөхцөлд ашиглагч, захиалагч, гүйцэтгэгч хамтран хэлэлцэн шийдвэрлэж, тэмдэглэл хөтөлж баримтжуулсан байна.
- БУА-д ашиглаж байгаа барилгын материалын чанар, стандартыг нотлох гарал үүсэл, тохирлын гэрчилгээ, сертификат бүрдүүлсэн байна.
- БУА-ыг фото зургаар баримтжуулсан байна.
- Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- Барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж, санхүүжүүлэх.
- Гүйцэтгэгч байгууллагын гаргасан албан хүсэлтийг үндэслэн БУА-ыг ашиглалтанд хүлээн авах Техникийн комисс ажиллана.

Зургаа. Жишиг маягт

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

ЦДҮС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], **220 кВ-ын бэлтгэл трансформатор-2-ийн ячейкийн тоноглолын суурийн барилга угсралтын ажил, ЦДҮС-2019/ИХБ-4/ХА03** дугаартай ажлыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр: \_\_\_\_\_

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга: \_\_\_\_\_

Албан тушаал, нэр: \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

## 2. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

### БАРИЛГЫН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ГЭРЭЭ

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс :  
Өөрийн хөрөнгө: 2019 онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь 220/110/35 кВ-ын “Сонгино” дэд станцад байршилтай 35 кВ-ын 2\*20000 кВар хүчин чадал бүхий шунтлэгч реакторын суурийн барилга угсралтын ажлыг \_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдөр эхэлж, \_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2 Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3 Үнийн санал
- 5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6 Техникийн тодорхойлолт;

- 5.7 Зураг;  
5.8 Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*